

БЭНСНИЙ ҮЛГЭР ДЭХ ЗАРИМ ХЯТАД ЗЭЭЛЛЭГ ҮГИЙГ ТОДЛОХ НЬ
(БҮРЭНБАЯРЫН ХУУРДСАН “ГУРВАН УЛСЫН ҮЛГЭР”-ИЙН ЖИШЭЭН ДЭЭР)¹

М.Жавхлан

Удиртгал

Түүхэн хөгжлийн урт замыг туулж аажмаар бүрэлдэн тогтсон хэлний үгсийн санг судлах нь үгсийн сангийн тогтолцоог зөв тогтооход чухал ач холбогдолтой бөгөөд аливаа хэлний судлалын нэг чухал салбар нь үгийн сангийн судлал байдаг. Үгийн сангийн судлалыг ерөнхийд нь “уугуул үг, харь үг, харь хэлэнд орсон монгол үг хэмээн бүрэлдэхүүн хувааж үздэг. Монгол хэлний үгийн сангийн зээлдсэн буюу харь гаралтай үгсийг гарал үүслээр тодруулан тогтоох нь монгол хэл, ямар ямар хэлтэй холбоо хэлхээтэй явж ирсний тодруулах боломж олгодог билээ. Тус өгүүлэлд уугуул монгол хэлний үг болон харь үг буюу ормол үгийн судлалын хоёр бүрэлдэхүүнийг сонгон авсан болно. Нэгжийн талаас үгийн гарал, үгийн утгын судалгааг чухалчлан анхаарч хуучин үг буюу түүхэн үгсийг ангилан сурвалж бичиг судлалын аргаар монгол хэлний дурсгалт бичгүүдээс сурвалжлан тайлахыг зорьсон юм. Аливаа сурвалж бол тухайн ард түмний нийгэм-түүхийн өвлөмөл оюун санааг уламжилж байдгаараа үнэ цэнтэй. Хуурын үлгэр бол түүнийг зохиосон, бас баяжуулан дэлгэрүүлж ирсэн хуурчийн аль алиных нь оюун санааны биежмэл ой санамж гэж үзэж болно. Тиймээс хуурдан хэлсэн бэнсний үлгэрүүдийн үгийн санг задлан үзэж түүнийг аль болохоор нээж гаргахыг тус өгүүлэлд зорьсон билээ. Ямар цаг үес, нийгэм-түүхийн ямар нөхцөлд, ямар зорилгоор тухайн сурвалж зохиогдож, түүнийг хайлан уламжилж ирсэн мэдээлэл бол чухал судлагдахуун болох нь эргэлзээгүй юм.

Хүн төрөлхтөн бичиг үсэгтэй болж, тэр ч байтугай орчин үед хүний өгүүлснийг хуурцагт буулган үлдээх, хадгалах боломжтой болсон нь хуурын үлгэрийг олон талаас нь судлан, түүнд агуулагдаж байгаа, хүн, хүний нийгэм, нийгэмшлийн тухай мэдээллийг нээж гаргахад ихээхэн дөхөмтэй болж байна. Хуурын үлгэр бол аялгуулан хуурдаж хайлдаг аман уламжлалыг бичмэл хэлбэрт оруулаад, улмаар түүн дээрээ үндэслэн дахин аман хэлбэрт аялгуулан хэлснийг соронзон хальсанд буулган бидэнд өвлөж ирсэн. Уг сурвалжийг өнгөрсөн цаг, одоо цаг гэж хатуу зааглалгүйгээр, түүхэн бодит байдалд нь агуулга, бүтцийг нь иж бүрнээр тодорхойлох боломжийг бүрдүүлж болно.

Тэгвэл академич Б.Ринчен “Монгол ардын аман зохиол дахь бэнсний үлгэр гэдэг зүйл” хэмээх өгүүлэлдээ “Монголчууд эрт дээр цагаас ардын аман зохиолыг тэмдэглэж авч байсан нь “Монголын нууц товчоон” зэрэг бичгийн дурсгалаас илэрхий байна. Түүний зэрэгцээгээр монголчууд бас бичгийн зохиолыг ярьж, аман зохиолын байдалтайгаар нэвтрүүлж байжээ. Үүний нэг жишээ нь бэнсэн үлгэрийн зүйл юм” гэж тэмдэглэсэн байдаг. Энэ нь хятад хэлний “本子 бэнз” буюу дэвтэр гэсэн үгийг хорчин аялгуунд “бэнс” хэмээн дуудсанаас үүсэлтэй.

¹ Тус өгүүлэл нь БНХАУ-ын Нийгмийн шинжлэх ухааны суурь мөнгөний анхаарагдаагүй буюу уламжлал тасарсан шинжилгээний салаагийн тусгай төсөл-Төвийн Үндэстний Их Сургуулийн Дунддын үндэстний уламжлалт соёлын солилцооны судлалын багийн төсөл болох “Монгол үндэстний аман уламжлал хийгээд монгол, хятад соёлын уусалцал” (20VJXT008)-ийн шатагч чанартай бүтээл болно.

Ер нь хятад хэлний “зы” гэдэг нэр үг бүтээх дагавар халх аялгуунд “с” авигаар дуудагдах явдал байдаг. Тухайлбал Ганз, данз хятад зэрэг хэлнээс монгол хэлэнд орсон зээллэг үгсийг “ганс, данс” гэх зэргээр дууддаг билээ. Дарьгангын аялгуунд “бэнзэн үлгэр гэх буюу бэнсэн үлгэр хэлдэг хүнийг “бэнзэч” гэж дуудаж байгаа нь манж хэлний bengsen буюу тэнхээ гэх үгээс орсон бололтой. Манж хэлний bengsen буюу тэнхээ гэх үг нь хятад хэлний 本事 ben shi чадвар, чадал, эрдэм хэмээх үг бөгөөд эрдэм чадлын үлгэр хэмээн үзэж болох юм. Монгол улсын говийн халхчууд ардын дууны цоморлог дэвтрийг “бянз, бэнз” гэж нэрлэдэг нь хятад хэлний дэвтэр гэсэн үг бололтой байна.

Ингээд эрт цагаас монгол, хятад хоёр үндэстэн зэрэгцэн амьдарч соёлын олон талт харилцаатай байсны анхны бичгийн баталгаа бол “Ачлалт номын тухай” хэмээх бүтээл юм. Энэ мэтчилэн “Зуун овгийн түүх” 百家姓 (дөрвөлжин үсгээр “事林广记/ Ши Линь Гуан И” гэсэн номын дотор), “Монголын нууц товчоон”, “Хуа-И И-Юй толь бичиг”, “Монгол хятад харилцааны бичиг” гэх зэрэг олон арван сурвалжуудыг нэг хэлнээс нөгөө хэл рүү орчуулж, тухайн хэлний үгийн санг авиалан тэмдэглэж байжээ.

Энэ уламжлалын залгамж болох хуурын үлгэр буюу бэнсний үлгэр нь XVIII-XIX зууны зааг дээр хорчин тал нутгаас үүсэж Жарууд, Жиримийн чуулган, Баарин, Хишигтэн, Авга, Сөнөд, Баруун зүүн Үзэмчин улмаар монгол улсын Дорнод халх, Дарьгангын хошуугаар дамжиж Богдын хүрээ хүртэл дэлгэрсэн байна. Энэ нь урт удаан хугацааны туршид манж, хан үндэстэнтэй улс төрийн нөхцөл байдлаас нэгэн улс болон хамтран амьдарч байсан нь соёлын нөлөөг хүртэхэд ихээхэн нөлөөлсөн бололтой.

Мин, Чин гүрний үеийн төлөөлөл Хятадын эртний дөрвөн сонгодог зохиолын нэг “Гурван улсын үлгэр”-ийг Чин улсын сүүл үеэс монгол хэлэнд орчуулан аман уламжлалаар монголчуудын дунд хүчтэй дэлгэрсэн байдгийг гадаад, дотоодод хадгалагдан үлдсэн орчуулан дэвтэрлэсэн эх сурвалжаас багтай мэдэж болно.

Тэгвэл Өвөр Монголын ихэнх аймаг хотын радио хорооноос шингээсэн дуу шингээлтийн текст нь голдуу дөрвөн хуурчийн “Гурван улсын үлгэр”-ийн доторх хэсэг агуулгыг сонгон хэлсэн хуурын үлгэрийг явуулдаг байв. Тэр нь Бүрэнбаярын “Гурван улсын үлгэр”, Жан Бөхийн “Гурван улсын үлгэр”, Шаравын “Лю Бэй Жин Жөү орсон нь”, “Барсын жанжин Ма Чао”, Хайбаогийн “Дун Жуог сөнөөсөн нь” зэрэг хуурдан хэлсэн үлгэр юм. Үүний дотор Бүрэнбаярын хуурдан хэлсэн “Гурван улсын үлгэр” нь бусдаасаа урд нийт 62 цаг, давхацсан тоогоор 280,000 орчим үгийн сантай, давхцаагүй тоогоор 21000 гаран үгсийн сантай тул үгийн сангийн задлал хийж ангилан судлахад тохиромжтой сурвалж билээ.

Нэг. Судалгааны тойм

Хуурын үлгэрийг өнөөдрийн байдлаар Монгол, Орос, Герман, Унгар, Англи, Япон зэрэг улсад судлаад байна.

Б.Ринчен 1929 онд хуурч Лувсангаас “Баруун тивийг эзэлсэн бодь мэргэн хаан” гэсэн үлгэрийг тэмдэглэн авч судлаад 1961 онд Германы “Азийн судлал”-д нийтлүүлсэн байна. Тэрээр 1959 онд болсон Олон улсын монголч эрдэмтдийн анхдугаар их хурал дээр “Монгол ардын аман зохиол дахь бэнсний үлгэр гэдэг зүйл” сэдвээр илтгэл тавьснаар хуурын үлгэрийг дэлхийн монгол судлаачдад танилцуулсан билээ.

Мөн Ц.Дамдинсүрэн “Монгол уран зохиолын дээж зуун билиг оршив” хэмээх бүтээлдээ Пажаа хуурчийн хуурдан хэлсэн “Сүн улсын хүйтэн уулын бичгийн хорин хоёрдугаар бүлэг”-ийг тайлбартай хэвлүүлсэн юм. Тухайн тайлбартаа “үлгэрч нар Хятадын романыг дуулахдаа өдий төдий нэмж чимж шүлэглэн монголын сонсогчдод тохируулсан шинэ зохиол мэт болгодог билээ” (1979:1616) гэж тэмдэглэв.

Д.Цэрэнсодном, Э.Түмэнжаргал, В.Л.Рифтин, С.Ю.Неклдзов, Вальтер Хайссиг, Г.Кара, Карал, Акара нарыг мөн дурдах нь зүйтэй.

1980 оноос хятад дахь хуурын үлгэрийн судлал эрчимтэй явагдаж Цагаанбар, Эрдэнэбаатар², Баянаа³, Алтанбагана⁴, 1980-1989 оны хооронд Нямаа, Баянаа, Ү.Сугар, Сэцэнмөнх, Бао Зуу, Чойжигав, Толь, Алтансанбуу, Нарсу, Доронго, Луузгар, Чимэддорж, Ү.Шинэбаяр, Сэцэнцэнгэл зэрэг судлаачид хуурч түүний бүтээл, хуурын үлгэр түүний урлаг, үүсэл хөгжил, урсгал бүлэг, үлгэрийн товчийг өгүүлсэн бүтээл зохиол, өгүүлэл нийтлэл гаргав. 1990 оноос хуурын үлгэрийн судалгаа нь голдуу онол судлал, тусгай сэдэв судлал, ерөнхийлсөн судлал гэх гурван чиглэлд хуваагдах болов. Хуурын үлгэрийн онол судлалаар Баатар, Цэцэг⁵, Буянхишиг, Төгсбаяр⁶, Оч⁷, Сэцэнмөнх⁸, Сампилноров⁹ нарын бүтээлүүд, хуурын үлгэрийн тусгай сэдэвт судалгаа нь голцуу хуурчийн тухай судалгаа, түүний хэв намба, урсгал бүлэг мөн хуурын үлгэрийн үүсэл, ая, хөгжим, зан үйл, бичгийн зохиол ба аман зохиолын харьцаа, урлагийн онцлог, нэр томъёо, соёлын үндэс, уран дүр зэрэг сэдвийн хүрээнд судлагдаж байна. Харин хуурын үлгэрийн ерөнхийлсөн судалгааг Цогт, Бао Жин Ган, Хуурын үлгэрийн дуу, хөгжмийн судалгааг Ян юй цэн нар хийж байна.

2000 оноос эхлэн хуурын үлгэрийг сонирхон судлах судлаачид нэмэгдэж тус хүрээнд докторын зэрэг хамгаалсан бүтээлүүдийг цуваа цагийн дарааллаар харвал Цогт “Хуурын үлгэрийн судлал”, Бао Жин Ган¹⁰, Хэ Хун Янь¹¹, Ян Юй Цэн¹², Бай Юй Рун¹³, Эрхэмбаяр¹⁴, Ли Цай Хуа¹⁵, Жюй Бао, Хувьсгалт¹⁶, Пэн Цүн Мэй¹⁷, Чи Жань Жу¹⁸, Хай Чюань¹⁹, Бао Саранчимэг²⁰, Бүрэнбаяр²¹, Сэргэлэн²², Бао Чин Юй²³, Цэлгэр²⁴ зэрэг 17 хүн докторын зэрэг хамгаалсан байна.

2013 оноос Хятадад хуурын үлгэрийн судлал эрчимжиж дотоодын болон олон улсын олон эрдэм шинжилгээний хурлыг уламжлал болгон зохион байгуулж, тус хугацаанд 200 гаруй эрдэмтэн судлаач нар хуурын үлгэрийн ерөнхий судлал, дагнасан хуурын үлгэрийн судлал, үлгэр хэлэх зан үйл хорио цээр, мотив болон дүрийн шинжлэл гэх мэт судалгааны олон салаа чиглэлээр илтгэл, өгүүлэл нийтлүүлсээр байгаагаас үзэхэд хуурын үлгэрийн судалгааны гол төв болсныг харж болно.

Эртний үргэлжилсэн үгийн зохиолч Луо Гуань жунгийн туурвисан “Гурван улсын үлгэр” түүхэн роман нь Хятадын эртний дөрвөн сонгодог бүтээлийн нэг юм. Зохиолч Луо Гуань жунгийг Юань гүрний сүүлч Мин гүрний эхэн үеэр буюу 1330-1400 оны хооронд Хятадын эртний Бэн жөү хотод (өнөөгийн Шаньси мужийн Тайюань хотод) амьдарч байсан

² Цагаанбар, Эрдэнэбаатар. *Хуурын үлгэрийн шинэ амилал*. Хөлөнбуйрын сонин. 1978.05.17.

³ Баянаа. *Хуурын үлгэрийг шинэчлэх хандшийн тухай*. ӨМӨС. 1978.09.23.

⁴ Алтанбагана. *Хуурын үлгэрийн үүсэл хөгжлийн тухай туршин өгүүлэх нь*. ӨМӨС. 1978.11.03.

⁵ Баатар, Цэцэг. 1985. *Монгол ардын аман зохиолын онол*. ӨМСХХ.

⁶ Буянхишиг, Төгсбаяр. 1990. *Монгол ардын аман зохиолын шинжлэл*. ӨМИСХХ.

⁷ Оч. 1999. *Монгол аман зохиолын удиртгал*. ӨМСХХ.

⁸ Сэцэнмөнх. 1992. *Хуур, хуурч, хуурын үлгэр*. Алтан түлхүүр. №1.

⁹ Сампилноров. 1999. *Бэнсэн үлгэр хийгээд хуурын үлгэрийн тухай ажиглалт*. ӨМҮБДС. №1.

¹⁰ Бао Жин Ган. 2003. *Хуурч ба хуурын үлгэр, холбоо, үлгэрт дуу*. Докторын диссертац.

¹¹ 何红艳: “科尔沁蒙古族说唱文学研究”, 苏州大学博士学位论文, 2005年。

¹² 杨玉成: “胡尔齐: 科尔沁地方传统中的说唱艺人及其音乐”, 中国艺术研究院博士学位论文, 2004年。

¹³ Бай Юй Рун. 2007. *‘Таван жуань’-ний уран зохиолын харьцуулсан судлал*. Докторын диссертац.

¹⁴ Эрхэмбаяр. 2010. *Хуурын үлгэрийн уламжлал тархаахуйн ухааны судлал*. Докторын диссертац.

¹⁵ 李彩花: “胡仁乌力格尔封神演义文本与汉文原著封神演义比较研究”, 中央民族大学博士学位论文, 2012年。

¹⁶ Хувьсгалт. 2013. *Хуурын үлгэрийн үүсэл бүрэлдлийн судалгаа*. ТҮИС. докторын диссертац.

¹⁷ 彭春梅: “胡仁乌力格尔: 从书写到口传以甘珠尔薛仁贵东征为例”, 中央民族大学博士学位论文, 2013年。

¹⁸ 齐占柱: 《胡仁乌力格尔与乌力格尔图哆亲缘关系研究》, 中央民族大学博士学位论文, 2013年。

¹⁹ Хай Чюань. 2015. *Хуурын үлгэрийн хүүрнэл зүйн судлал*. БХҮИС. Докторын диссертац.

²⁰ Бао Саранчимэг. 2016. *‘Шювай ган тан улсаас урвасан нь’ гэх үлгэрийн текст судлал - хуурын үлгэр ба уг хятад эхийн жишээнд*. Докторын диссертац.

²¹ Бүрэнбаяр. 2018. *Хуурын үлгэр ‘Хувилгаан оддын шастир’-ын тухай судлал*. ТҮИС. докторын диссертац.

²² Сэргэлэн. 2018. *Хуурын үлгэрийн радио текст судлал-Төмөрийн ‘Гада мэйрэн’ гэх үлгэрийн жишээн дээр*. Докторын диссертац.

²³ Бао Чин Юй. 2019. *У Доржийн хэлсэн хуурын үлгэр ‘Да ши лян’-гийн уран дүрийн судлал*. Докторын диссертац.

²⁴ Цэлгэр. 2020. *Бүрэнбаяр хуурчийн хэлсэн ‘Гурван улсын үлгэр’-ийн харьцуулсан судлал*. Докторын диссертац.

төлөвтэй гэж судлаачид магадалдаг. Тэрээр бас “Сүй, Тангийн бичиг”, “Сүй Хүгийн үлгэр” зэрэг томоохон бүтээлүүдийг туурвисан байна. Луо Гуань жунгийн “Гурван улсын үлгэр” нь хятадын орчин үеийн уран зохиолд ихээхэн нөлөө үзүүлсэн нь түүнийг улам нэртэй болгожээ.

Чянь Чэнь лигийн үзэхээр, барууны эрдэмтэд Хятадын эртний уран зохиолыг өнгөрсөн гучин жилийн турш судалсаар ирсэн хэдий ч хятадын эртний дөрвөн сонгодог бүтээлийн нэг болох “Гурван улсын үлгэр” ба АНУ-ын Хятад судлаач, орчуулагч Луо Мүши буюу Moss Roberts-гийн англи хэлнээ орчуулсан “Гурван улсын үлгэр”-ийн хувилбар нь хэдийгээр бүрэн эхээр нь орчуулсан ч уншигчдын хүртээлийг бүрэн дүүрэн олж чадаагүй байна²⁵.

Шэнь Бүө жүньгийн “Шинэ зууныг угтсан “Гурван улсын үлгэр”-ийн судалгаа гэх өгүүлэлд: Хятад, Япон, барууны орнуудад “Гурван улсын үлгэр”-ийн судалгаа идэвхтэй өрнөж, хятадаар төвлөрүүлэн гадагш тэлэх чиг хандлагаар хөгжиж байна. Үүнд бүс нутгаараа, Япон, Солонгосын тойрог, Тайланд, Малайз, Вьетнам, Индонез зэрэг өмнөд Азийн тойрог, Орос, Англи, Франц, Австрали, Америк зэрэг барууны орнуудын тойрог гэж ихэвчлэн гурван бүлэгт хуваажээ²⁶.

Барууны орнууд дахь “Гурван улсын үлгэр”-ийн судалгаа өнгөрсөн зууны далаад оноос эхэлжээ. Төлөөлөх судлаачдыг дурдвал, Boris Riftin, Andrew West, Ms.Claudine Salmon, Ma Лань-ань нар юм.

“Гурван улсын үлгэр”-ийн судалгаа нь Хятадын соёлыг дэлхий дахинаа түгээн дэлгэрүүлэхэд чухал ач холбогдол үзүүлсэн ба үүний доторх орчуулгын ач гавьяа, үнэ цэн их билээ. “Гурван улсын үлгэр”-ийг анх 1689-1692 оны хооронд япон хэлнээ орчуулж эхэлснээс өнөөг хүртэл нийт 20 гаран хэлээр орчуулагдаад байна. Үүнд: англи хэлнээ Charles Henry Brewitt-Taylor (1857-1938)-ийн орчуулсан нь анхны бүрэн эхийн орчуулга болно. Дараагаар Moss Roberts-ийн орчуулга юм. Jinhee Kim-ийн орчуулсан солонгос хэлний “Гурван улсын үлгэр” уншигчдын хүрээлэл хандлагыг ихэд хүлээж, ялангуяа сүүлийн жилүүдэд “Гурван улсын үлгэр”-ийн олон хувилбар өргөн дэлгэрч, улс үндэстэн, үг хэл, соёл иргэншлийн зааг шугамыг саадгүй давж, нийтлэг ойлголт ололтыг хүртэж чаджээ²⁷.

“Гурван улсын үлгэр”-ийн англи орчуулгын судалгаа нь Хятадын сонгодог бүтээлийн англи орчуулгын судалгааны чухал сэдэв болсон байна. Судлаач Вэнь Жүнь, Ли Бэйжя нарын 2011 онд авсан судалгаагаар 1982-2010 онд “Гурван улсын үлгэр”²⁸-ийн англи орчуулгыг судалсан эрдэм шинжилгээний 70 гаруй өгүүлэл нийтлэгдээд байна.

Харин “Гурван улсын үлгэр”-ийг XIX зууны жараад онд анх манж орчуулгаас нь монгол хэлнээ орчуулсан гэдэг. Тухайлбал, Инжинаш (1837-1892) монгол хэлнээ анх орчуулсан боловч тус эх олдоогүй тухай Тэмгэт “Гурван улсын үлгэр”-ийг орчуулах үеийн тэмдэглэлдээ бичсэн байдаг. Гиймээс одоогоор 1928 онд Тэмгэтийн орчуулсан эх нь монгол хэлэнд орчуулсан эхний бүрэн бүтэн орчуулга болжээ.

“Гурван улсын үлгэр” сонгодог романы монгол орчуулгын дөрвөн янзын хувилбар байдгаас манай улсын төв номын санд хадгалагдаж байгаа хоёр хувилбарыг Мишиг, Б.Рифтин нар гүүш Дахайгийн орчуулсан манж эхтэй тулган судалж байсан билээ.

Монгол улсаас гадна Орос, Хятад, Герман, Дани, Америк, Япон, Унгар, Швед зэрэг улсуудад дээрх хувилбарууд хадгалагдаж байна.

Түүхэн сурвалж бичгүүдээс үзэх юм бол Манжийн гүүш Дахай 1600-аад оны эхээр “Гурван улсын үлгэр” сонгодог романыг орчуулж байгаад дуусгаж амжилгүй бие барсан

²⁵ Qianchen Li. 2009. *A Book Review on Three Kingdoms and Chinese Culture*. JAS (Volume 68, Issue 4, pp 1242-1243). Published online by Cambridge University Press.

²⁶ «三国演义» 与中国文化 述评作者: 骆海辉, 绵阳师范学院外国语学院副教授; 王海燕, 绵阳师范学院外国语学院讲师, 四川 绵阳621000.

²⁷ 出自韩文三国演义与中国文化

²⁸ 文军’ 李培甲.国内《三国演义》英译研究: 评述与建议[J].北京第二外国语学院学报, 2011, (8)

байна. Хожим түүнийг засгийн хэргийг шийтгэгч сайд Доргуны тушаалаар хожуу үеийн гүүш нар нөхөн гүйцээж, 1650 онд Бээжин хотноо модон бараар манж үсгээр хэвлэн найман тугийн цэрэг дайчдад цэргийн аргын ном болгон тарааж Дахайгаар овоглогддог энэхүү манж орчуулгыг хожим манай гүүш нар эх зохиол болгон ашигласан нь 1800-аад оны дунд сүүл үе гэхэд хэд хэдэн янзын хувилбараар бичгийн мэргэдийн дунд тархаж байжээ.

Рифтин найруулан, Ян Ли Фан, Тянь Янь Чю орчуулсан “Зүүн монголын хуурч хийгээд хятад үлгэрчийн баатрын хүлэг морь дүрслэлийг адилтгах нь” гэх эрдэм шинжилгээний өгүүлэлд хуурч Номинхүрдийн хуурдан хэлсэн “Гурван улсын үлгэр”-ийн доторх хүлэг морь, баатар жанжны дүрслэлийг эшлэн ашигласан байдаг.

Жюй Бао ““Гурван улсын үлгэр”-ийн монгол орон дахь тархалтын судлал”-даа “Гурван улсын үлгэр”-ийн монгол оронд уламжлагдан тархсан чухал хэлбэр болох орчуулга ба хуурын үлгэр гэх хоёр гол сэдвээр тогтолцоотой судалсан бөгөөд шүлэг дуулал, шүүмж судлал зэрэг бичгийн тархалтын хэлбэр, хуурын үлгэр, явган үлгэр, ардын дуу ба холбоо зэрэг аман тархалтын хэлбэр, зурагт дэвтэр, телевиз жүжиг ба хүүхэлдэйн жүжиг зэрэг дүрст тархалтын хэлбэр зэрэг олон талын асуудлыг хөндөн танилцуулсан байна²⁹.

Ш.Хасбаатар ““Гурван улсын үлгэр”-ийн монгол аман зохиол дахь нөлөө”³⁰, Цэлгэр “Бүрэнбаяр хуурчийн хэлсэн гурван улсын үлгэрийн харьцуулсан судлал”, “Хуурын үлгэр “Гурван улсын үлгэр”-ээс Хятад, Монголын соёлын солилцоог ажиглах нь ““Жао зи лүн цэнээ поод ихээр байлдсан нь” үлгэрийн жишээн дээр”, Шю юнь-ий “Хуурын үлгэр “Гурван улсын үлгэр” доторх “Жао зи лүн цэнээ поод их л байлдсан нь” гэдэг үлгэр дэх хятад соёлыг задлах нь”, Шю юнь ба Пен цүн мейгийн “Хуурын үлгэр “Гурван улсын үлгэр”-ын монгол үндэстний утга урлаг, зан үйлдэх нөлөөг туршин өгүүлэх нь” зэрэг судалгаануудаас үзэхэд хуурын үлгэр, “Гурван улсын үлгэр”, Бүрэнбаяр хуурчийг судалсан судалгаа олон талаас судалсан боловч үгийн сангийн судалгааны сурвалж болгон ашигласан нь хараахан харагдахгүй байна.

Монгол хэлний харь үгсийн тодорхой хувийг хятад хэлний зээллэг эзэлдэг билээ. Я.Ганбаатар И.Т.Зогроф³¹, Ж.Кара, Х.Серрюс, Н.Туяацэцэг, С.Мөнхсайхан нар монгол хэлэнд орсон хятад зээллэг үгс, Г.Гантогтох³², Ц.Б.Цыдендамбаев³³, Ц.Б.Будаев³⁴ буриад аялгуун дахь хятад зээллэг үгс, Ц.Д.Номинханов³⁵ халимагуудын хэлэнд орсон хятад үгсийн талаар судалсан байдаг.

Манай судлаачдын бүтээлээс харахад: “Монгол, хятад ард түмнүүд эрт үеэс харилцаа холбоотой явж ирсэн хэдий ч хэл, соёл, шашин шүтлэг, амьдралын хэв маяг ондоо учир монгол хэлэнд хятад үг нэвтрэхдээ их төлөв энгийн ярианы замаар худалдаа арилжааны үйлстэй холбогдон орсон нь тодорхой харагдаж байна”³⁶ хэмээн дүгнэсэн байна. Дэлгэрүүлбэл, 13-14 дүгээр зууны үеийн монгол бичгийн хэлний дурсгалууд дахь хятад зээллэг үгийн бусад судалгаан дээр тулгуурлан Монголын нууц товчоонд 18 үг (нийт үгийн сангийн 0,2 хувь), дөрвөлжин бичгийн монгол дурсгалуудад 32 үг (нийт үгийн сангийн 2,1 хувь), Хуа-и и-юй толь бичгийн монгол орчуулгад 15 үг (нийт үгийн сангийн 1,7 хувь) байгаа нь үгийн сангийн бага хувийг эзэлж буй бөгөөд энэ нь бидний өвөг дээдэс эх хэлээ эрхэмлэн зайлшгүй тохиолдолд харь үг авдаг байсныг гэрчилж байна. Харин С.Мөнхсайхан “Монгол

²⁹ Жюй Бао. 2013. *Гурван улсын үлгэрийн монгол орон дахь тархалтын судлал*. ӨМХХ. 1.

³⁰ Ш.Хасбаатар. 2005. *‘Гурван улсын үлгэр’-ийн монгол аман зохиол дахь нөлөө*. ӨМИС. ЭШС. №5.

³¹ Я.Ганбаатар. 2008. *Өвөг ба эртний монгол хэлний судалгаа*. Улаанбаатар.

³² Г.Гантогтох. 1995. *Хятад хэлнээс монголжиж буриад аялгуунд орсон үгс*. Историко-сравнительное изучение монгольских языков. Улан-Удэ.

³³ Ц.Б.Цыдендамбаев. 1972. *Бурятские исторические хроники и родословные*. Улан-Удэ, 663 стр.

³⁴ Ц.Б.Будаев. 1992. *Бурятские диалекты (опыт диахронического исследования)*. Новосибирск., 217 стр.

³⁵ Ц.-Д.Номинханов. 1975. *Материалы к изучению истории калмыцкого языка*. М, 324 стр.

³⁶ Редактор Ж.Баянсан. 2020. *Зохиогч Ш.Баттөгс, Э.Пүрэвжав, Б.Түвшинтөгс, Г.Гэрэлмаа, О.Шинэбаяр, Д.Ганболд нарын “Монгол хэл судлалын түүх-Монгол хэлний үгийн сан, найруулга судлал III боть”*. МУИС-ийн МСХ, 26-27. Улаанбаатар.

хэлний хятад гаралтай үг” хэмээх бүтээлдээ 850 орчим хятад зээллэг үгийн тайлбарлан хавсаргажээ.

БНХАУ-ын бүрэлдэхүүнд багтаж байгаа Өвөр монголчуудын үгийн санд хятад хэл их бага хэмжээгээр нөлөөлсөн билээ. Энэ талаар Бөхөө³⁷, Түргэн³⁸, Ү Жинфүн³⁹, Сэцэнмөнх⁴⁰, Баярмэнд⁴¹, Эрдэнэтогтох⁴², Ман.Мөрөн⁴³, Хасбаатар⁴⁴, Цагаансар⁴⁵ Юн Фань, Мань-Лянь⁴⁶ нар монгол угсаатны утга зохиолын хэлэнд монголчуудын хэл ярианд нэвтэрч буй хятад үгсийн тухай судалсан байна.

Монгол хэлэнд орсон зээллэг үгийн судалгааг ихэнх судлагдахуунаас судалсан боловч бэнсний үлгэр, хуурын үлгэрийн үгийн сангаас судалсан нь хараахан үгүй байна.

Ийнхүү монгол хэлний үгийн сан дахь харь гаралтай үгсийн судалгааг шүүн үзвэл хятад хэлний зээллэг үг хэллэг элбэг байх бөгөөд түүний дараагаар санскрит, төвд болон манж үгс байх ажээ. Энэ нь эдгээр улсын соёлын нөлөө болон хоорондын харилцаа холбоотой шууд холбоотой юм. Иймийн тул, энэхүү судалгаандаа монгол хэлэнд орсон хятад хэлний зээллэг үгсийн судлалд бэнсний үлгэр болон хуурын үлгэрийн сурвалжийг анх татан оруулж байна.

Хоёр. Хятад гаралтай зээллэг үг

Монголчууд бид түүхэн байдлаас харвал манай эриний тодорхой бус үеэс 13-р зуун хүртэл монгол, хятад үндэстний арилжаа худалдаа, соёл, иргэний янз бүрийн харилцаатай уялдаж олон зуун үг хэллэг харилцан нэвтэрсэн байна гэж үзүүштэй байдаг. Харин 13-р зуунд монгол, хятад хоёр үндэстэн нь нэг төрт ёсны доор захирагдан суухдаа бичиг, соёл болон бусад олон зүйлийн харилцаанаас үүдэж олон үг хэллэг харилцан нэвтэрсээр ирсэн нь тодорхой болдог.

Түүхэн харилцааны тухай цаг үед монгол хэлэнд орж, тэдгээрийг түүх, хэл, соёлын мэргэшсэн судлаач л биш бол харь гаралтай үг гэж мэдэгдэхгүй болтлоо хэвшин хэрэглэгдэх болсон үгс цөөнгүй байгааг бидний энд жишээлэн сонгосон үгсээс харж болно. Жишээлбэл: ваар, данс, дэнс гэх мэт. Гэвч ийм үгсийн санг цаашид шинжлэхдээ эх хэлэн дэх анхны утга нь хэрхэн өөрчлөгдсөнийг харьцуулан, зохих гаргалгаа дүгнэлт хийх нь чухал гэж үзэж байна. Тухайлбал, бидний жишээлсэн үлгэрт данс гэдэг нь хятад хэлэндээ бүтээлэг, хуудас гэсэн утгатай бол монгол хэлэнд тоо бүртгэл, баримтыг жагсаан бичсэн тэмдэглэл тоо бүртгэл, баримтыг жагсаан бичсэн тэмдэглэлийг нэрлэдэг. Мөн дэнс нь бидний үлгэрт гарч байгаа жишээн дэх хятад үг нь алт мөнгө хэмжих хэмжүүрийг хэлдэг бол харин монгол хэлэнд алт мөнгө зэргийг хэмжих жинлүүрээс гадна сэтгэлийн хатыг зааж мөн амьдралын дэнс буюу хагацал учрал, цөхрөл итгэл гээд амьдралын түмэн өгөгдлүүдийн дундах торгон мөчид хүний сэтгэлийн үелзэл хамгийн дээд хэмжээсийг заах илэрхийлэх зэрэг шилжсэн хоршоо үг хүртэл үүсгэсэн байна.

³⁷ Бөх. 1958. *Монгол хэлний доторх хятад гаралт үгсийн тухай*. МТХБ 12. 8-13. Хөххот.

³⁸ Түргэн. 1959. *Монгол шинэ бичгийн хэлэн дэх хятадаас зээлдсэн үгийн байдал*. МХУЗ 4 (38). Хөххот 14-27.

³⁹ Ү Жинфүн. 1959. *Монгол шинэ бичгийн хэлэн дэх хятад хэлнээс зээлдсэн үгийн байдал*. МХЗТ 4 (38). Хөххот.

⁴⁰ Сэцэнмөнх. 1991. *Монгол улсын өнөөгийн хэлэнд хэрэглэгдэж байгаа хятад гаралтай үгсийн тухай*. ГУНШУ. Хөххот.

⁴¹ Баярмэнд. 1991. *Монгол хэлний зээллэг үгийн тухай*. ӨМБИС. ЭШС. Хөххот.

⁴² Эрдэнэтогтох. 1960. *Дагуур хэлэнд байгаа хятад хэлнээс зээлдсэн үгсүүд*. МХЗТ 2. 17-24. Хөххот.

⁴³ Ман Мөрөн. 1992. *Монгол хэлний харь гаралтай үгсийн ирэл гарлын тухай*. МСӨТ. ӨМСХХ. 388-399. Хөххот.

⁴⁴ *Монгол хэлэн дэх хятад зээллэг үгийн асуудлууд*. 2002. Монгол хэл зохиол. №5. Улаанбаатар.

⁴⁵ Цагаансар. 2004. *Уйгуржин монгол үгсийн дурсгалт бичигт хятад зээллэг үгийг тэмдэглэсэн онцлог*. ӨМИС 1. 61-67. Хөххот.

⁴⁶ Юн Фань, Мань-Лянь. 2012. *Хорчин аман аялгууны соёлын орчин ахуй ба хятад зээллэг үгийн тухай өгүүлэх нь*. МУИС, МХСС-ийн ЭШБ. XXXIV(360). 104-124. Улаанбаатар.

Ваар нь хятад хэлэнд шавар, шороогоор хийсэн байшингийн дээврийн материалыг хэлдэг бол монгол хэлэнд наанги улаан шороогоор тодорхой хэлбэрт оруулан барьж галд хийсэн сав суулга, байшин барилгын дээвэр ховхи мэт матгар хэлбэртэй тоосго, дээврийн ваарын завсар үүрээ засах хятруу бялзуухайг ваар бялзуухай хэмээн утга нь ихээхэн өөрчлөгдсөн байх жишээтэйг нарийвчлан үзнэ гэсэн үг юм.

Бидний судалгааны гол хэрэглэгдэхүүн болох Бүрэнбаяр хуурчийн хэлсэн “Турван улсын үлгэр”-т илэрч буй бусад монгол хэлний нутгийн аялгуунд зээлдэн тархсан цөөн хэдэн үгийг доор судлаачдын санал дүгнэлтэй харьцуулан жишээ тайлбартай авч үзье:

jegeli (ᠳᠵᠢ:ᠯ): *araljij-a mayimai-yin saγuri qota jegeli mayudajei* хэмээх өгүүлбэрт илэрч буй **зээл** хэмээх үгийг Монголын судлаачид хятад хэлний *jiē* (街) буюу гудамж, зах хэмээх үг гэж үзжээ. Тэгвэл хятад хэлэнд *jiē* хэмээн авиалан дуудах болсон нь нэлээн хожуу үед бөгөөд эртний дуудлага нь *gai* байсныг хятадын судлаачид тэмдэглэж байна. Тиймээс монгол хэлний зээл хэмээх үгийн гарлыг хятад үг хэмээн үзэх нь барим сэлт дутуу санагдаж байна.

jegetüü (ᠳᠵᠢ:tu:): *jiber-ün üjügür deger-e jegetüü ugei bolbaču jabi subay-i γartal-a-ban čini keyisgečigekü-ni γayiqaltai* Тус өгүүлбэрт илэрч буй **зээтүү** нь хятад хэлний *juétóu* 馱头 хэмээх газар малтах зориулалттай багаж, гоотуутай төстэй багаж хэмээн хятад хэлний тайлбар толиудад тэмдэглэсэн байна. Энэ мэтчилэн газар тариалангийн гаралтай үгс хятад хэлнээс монгол хэлний үгийн санд орсны нэг баталгаа энэ зээтүү, жоотуу хэмээх үг билээ.

sang (saŋ): *egün-i jalaju ireged učir-i jöbleged, tere kümün a ged küliyegseger alta mönggü-yi tegün-ü sang kömürge-eče-ben γaryan-a* Тус өгүүлбэрт илэрч буй **сан** нь монгол хэлний сан-г тэмдэглэсэн 8 утгаас улсын мэдлийн өмчид холбогдох эд хөрөнгийг хэлж буйтай дүйж байна. Сан хэмээх үгийг олон судлаач хятад хэлний будаа тариа хадгалах хөмрөгийг зааж буй *cāng* 倉 хэмээх үг гэж үзсэн байдаг. Тус үг 13-14-р зууны монгол дөрвөлжин бичгийн дурсхалуудад ‘c’aŋ tamqa’, ‘c’aŋ amu’ холбоо үгээр олонтоо тохиолддог бөгөөд тэр нь ‘үр тарианы татвар’, ‘хадгалсан үр тариа’ гэсэн утгатай. Тэгвэл Д.Төмөртогоо “Энэ үг яваандаа агуулах сан гэсэн утга илэрхийлэх болсон бөгөөд тэр нь монгол хэлний эд баялаг гэсэн утгатай *sang* гэдэг үгтэй утга ойртож, монгол бичгийн хэлэнд мөн *sang* хэмээн бичигдэх болжээ” (2018:21). Тэгвэл зарим түүхэн сурвалжаас харвал, Монголын нууц товчооны 279 дүгээр зүйл 者別倉兀_揚 秃速_舌兒抽 / *jebe sanggut tüsür=čü* буюу **зэв сангууд түсэрч** хэмээн сангууд хэмээн гарч буй нь амуу тарианы зүйлийг зааж байна. Бодичариявадарагийн монгол тайлбарын 156a1 талд *oγtorγui-yin sang metü bügüde daγusqal-ügei ed tabar-tan boltuγai*⁴⁷ (огторгуйн сан мэт бүгд дуусаишгүй эд таваартан болтугай), 1268 оны Хубилай хааны зарлигийн 22 мөрт *qan-u sang büü čidqutuyai*⁴⁸ (хааны амуу тарианы санг бүү асгамугай), Хятад-Монголын харилцааны бичгийн B17 *ba qaračus bo’öld-i enerin sang künesün ba qubčad soyurqaju*⁴⁹ (бидний харц, боолуудыг энэрэн үр тариа ба хувцас хунар соёрхож) тус тус гарч байна. Үүнээс үзэхэд тухайн үг нь 13-р зууны үед монгол хэлний үгийн санд орсон байна.

čaling (čəlyŋ): *činu idejü шүγиqu čaling püŋglü ügei üü?* Тус өгүүлбэрт илэрч буй цалин хэмээх үг нь анх арилжааны хэрэгсэл болох цагаан мөнгөн зоосыг нэрлэж байгаад хожим мөнгөөр олгодог ажлын хөлсийг нэрлэх болсон. *čaling* хэмээн монгол үг нь хятад хэлний эрт цагийн тарианы татвар, чин улсын гол эдийн засгийн туслагч нарыг нэрлэдэг *qianliang* 钱粮 хэмээх үгээс ирсэн бололтой.

⁴⁷ E. Haenish. 1954. *Mongolica der Berliner Turfan Sammlung*. I. Ein buddhistisches Druckfragment vom Jahre 1312, ADAW Nr. 3, 1953, S. 22 + 24 Tafeln. Berlin.

⁴⁸ D. Tumurtogoo. 2006. *Mongolian Monuments in Uighur-Mongolian Script (XIII-XVI Centuries)*. Taipei. 12-14.

⁴⁹ H. Kuribayashi. 2003. *Word- and Suffix-Index to Hua-yi Yi-yu based on the Romanized Transcription of Ligeti*. Sendai. 63-166.

süm-e (sum): *eyimü-eče tüsimel qo yuwang ebüged-ün süm-e-dür yosulaju* Тус өгүүлбэрт илэрч буй монгол хэлэнд мөргөл үйлдэх дуган сүм нь 1261 оны Хубилай хааны зарлигийн бичгийн 17 дугаар мөрт sümes⁵⁰, Бодичариявадарагийн монгол тайлбарын 167b8 талд *Daidu daki čaγayan suburγatu yeke süme-dür tamγa čoyulyayulju*⁵¹ (*Дайду дахь цагаан суваргат их сүмд хэв сийлүүлж*), Мукаддимат ал-адаб толийн монгол хадмал орчуулгын 329 дүгээр талд *süme храм*⁵² гэх зэргээр эрт үеийн сурвалжууд тэмдэглэн үлдсэн байна. Тус үгийг сүм дуган, сүм хийд гэх хоршоо үгээр мөн хэрэглэгдэж байна. Харин манай зарим судлаачид утгыг баримтлан хятад хэлний simiao (寺庙, сүм) хэмээх үгээс гаралтай (Мөнхсайхан, 2014:200) хэмээн тэмдэглэсэн нь хангалттай баримт нотолгоо болж чадахгүй байна.

tayibuu (daibə: ~ taibə:): Монгол хэлэнд тухайн үг нь хуучирсан бөгөөд тайфуугийн дараах түшмэлийн цол, хааныг залгамжлах хөвүүнийг заан сургах туслах түшмэлийн цолыг хэлдэг байж. Хятад хэлний түшмэлийн цол хэмээх утгатай taibao 太保 хэмээх үг билээ.

tayian (taigan): Хятад хэлний хаанд үйлчлэх, агтлуулсан хүнийг taijian 太监 гэдэг бөгөөд монгол хэлэнд тухай утгаараа зээлэгдэн орсон байна.

tayizi (tai dzi): Монгол хэлэнд хятад хэлнээс taizi хэмээх дуудлагатай өндөр тавцан táizi 台子, хаан ор залгах хөвгүүн 太子 taizi хэмээх хоёр үг шууд утга дуудлагаараа зээлэгдэн орсон байна.

tayikeü (tai xu): Хятад хэлэнд эх хатныг taihu 太后 гэдэг бөгөөд монгол хэлэнд хааны эхийн цол хэмээн хүлээн авчээ. Чин улсын үед зарим хааны ээж нь тодорхой хугацаанд хааны эрхийг эдлэн, шийдвэр гаргаж байснаас улбаатай ийн тайлбарласан байна.

tayisi (tə:f): Хятад хэлний их багш taishi 太师 хэмээх үг нь монгол хэлэнд нэлээд эрт орсныг сурвалж бичгийн баримтуудаас харж болно. Лувсанданзаны “Алтан товч” д “Жалайрдайн сайн Мухали хүчин өгсөн олон буй хэмээн Гүй ван чинсан тайш цол өгч, зүүн гарын түмнийг мэдүүлбэй” хэмээн гарснаас хойш 1206 оноос 15 дугаар зууны үеэс алтан ургийн бус язгууртны хамгийн том цол байсан байна. Мөн “Айлтгал бичиг”-т *umaradu mongyol köbegün Bigeslan taiši*⁵³ (*умард монгол хөвүүн Бигэслан тайш*), Монголын нууц товчооны 50 дугаар зүйлд 把兒壇 把阿秃⁵⁴ 侖 可兀^揚 忙格秃 乞顏 捏坤 太子 也速該 把阿秃兒/ *Bartan ba'atur-un kö'üt Möngetü Kiyān Nekün taiši Yisügei ba'atur* (*Бартан баатрын хөвүүд Мэнгэту хиан, Нэхүн тайш, Есүхэй баатар*) хэмээн гарч байна. Тайш хэмээх үгийн талаар тусгайлан эрдэмтэн Н.Сегуус⁵⁴ судалсан байна. Монгол хэлний тайлбар толиудад Юань гүрний үед тэргүүн дэсийн бичгийн сайдыг тайш хэмээн нэрийднэ гэж тайлбарласан байна.

quwangkeü (xoaŋ xu): Хятад хэлэнд хуандийн эхнэр huanghou 皇后 хэмээн нэрлэдэг байна. Монгол хэлэнд тайлбарлахдаа хааны эх буюу их хатан хэмээн тайлбарласан байна. Харин хятад хэлэнд хааны эхийг mǔhòu 母后 хэмээн тусгай нэрлэдэг байна.

qas (xas): *qanusi ügei sedkil qas tan-a-yi kedüi ügbel kedüi bayarlaju-la bayin-a* Тус өгүүлбэрт илэрч буй кирилл үсэгт хас ба хаш гэх хоёр өөрөөр бичдэг ч үгийн утга нь гоёл чимэглэлийн үнэт чулууг хэлдэг. Тухайн үгийг олон монгол улсын харь үгийн гарал судалж буй эрдэмтэд хятад хэлнээс гаралтай хэмээн үздэг билээ. Тухайн үг нь “Жигүүнтэйн дурсгалд зориулсан хөшөөний бичиг” ийн 25 дугаар мөрт *nigen qas büs-e ögügsen айуи*⁵⁵ (*нэгэн хас бүс өгсөн ажгуу*) хэмээн гардаг. Хятад хэлэнд хасыг 玉 гэдэг бөгөөд Өвөр монгол хүний нэрд их орсон байдаг.

⁵⁰ D.Tumurtogoo. 2006. *Mongolian Monuments in Uighur-Mongolian Script (XIII-XVI Centuries)*. Taipei. 12-14.

⁵¹ E.Haenish. *Mongolica der Berliner Turfan Sammlung*. I. Ein buddhistisches Druckfragment vom Jahre 1312, ADAW Nr. 3, 1953. Berlin. 1954. S. 22 + 24 Tafeln.

⁵² Поппе Н. 1938. Монгольский словарь Мукаддимат ал-Адаб, Труды института Востоковедения XIV, часть I-II, М-Л. Добу. 1983. *Уйгуржин монгол үсгийн дурсгалт бичгүүд*. Бээжин.

⁵⁴ The Office of Tayisi in Mongolia in the Fifteenth Century. 1977. HJAS 37. 353-380.

⁵⁵ F.W.Cleaves. 1951. The Sino-Mongolian Inscription of 1338 in Memory of Jigün-tei. HJAS 14. 1-104.

Гэвч хас хэмээн орчуулан монгол нэрээ хэрэглэдэг билээ. Тиймээс хаш хэмээх үг нь хятад хэлнээс гаралтай гэх нотолгоо хараахан байхгүй байна.

quwar (xоar): Хятад хэлний цэцгийг хэлж буй *huāer* 花儿 хэмээх үг нь монгол хэлний үгийн санд хэдий үед зээлэгдэн орсныг нягтлан үзэх баримт сэлт олдоогүй билээ. Ямартай ч монгол хэлэнд хуар цэцэг хэмээн давхар орчуулан зээлэн авч хэрэглэсэн байна. Бидний сурвалжид илэрч буй хуар хэмээх үг нь зураг, зурлага гэсэн утгыг зааж буй *huaer* 画 хэмээх хятад үг билээ. Монгол зураг хэмээх утгыг агуулж буй ч гоёл чимэглэл болгосон цэцгийн дүрс, хээ угалзын зүйлийг нэрлэж байна. Хуарлах, хуартай, хуархаг гэх үүсмэл үг бүтсэн бол хуар гаргах, хуарын утас, хуар зураг, хээ хуар гэх мэт холбоо үгийг ч мөн үүсгэсэн байна.

qundan (xondyn) Хятад хэлний улаан цайвар гэх *hóngdān* 红丹 хэмээх үг нь монгол хэлний ямарваа нэг өөр өнгөний хольцгүй, цул өнгийг хэлж буй *qundan* хэмээн үг бололтой.

qauli (xө:l): *kūmūn-ü sedkil temür metü qatayū getel-e-ben qaulidaqu alba-yin qauli gedeg čini bol kögerge-yin yal metü yum-a* Хууль хэмээх үгийн гарлыг хятад хэлний зүй тогтол, жам хууль *guīlǜ*, хууль цааз *fǎlǜ* гэсэн үгнээс үүссэн хэмээн үзэх эрдэмтэд цөөнгүй байна. Д.Төмөртогоо тус үгийн гарлыг түрэг хэлнээс орсон хэмээн өөрийн бүтээлдээ тэмдэглэсэн байна⁵⁶. Тэгвэл тус үг монгол бичгийн дурсгалуудад хэдий үеэс илэрснийг харвал, Айлтгал бичгийн 22b талд *edüge boyol jerge-yi qauli-bar öčimü*⁵⁷ (эдүгээ боол зэргийг хуулиар өчмүү), Мөн “Монголын нууц товчоон”-ы 229 дүгээр зүйл 門 門約速阿兒 額捏 卞合兀里巴 兒 帖因 乞禿該 *mūn mūn yosu'ār ene qauli-bār teyūn kītūgei* (мөн мөн ёсоор энэ хуулиар тийн хийтүгэй) хэмээн гарч буй бөгөөд хажуугийн хятад орчуулгад дагуу хэмээн 體例依着 тайлбарласан байна. Энэ мэтийн баримтаас харахад энэ аль 13-р зуунд монгол хэлний үгийн санд идэвхтэй хэрэглэгдэж байсныг үзвэл хятад хэлний үгийн сангаас орсон хэмээх нотолгоо хараахан дутмаг байна. Өнөө бидний хэрэглээнд хувирч өөрчлөгдөхгүй зүй тогтол, дагаж мөрдөх дүрэм журам, юмс үзэгдлийн хоорондын жам ёсоор илэрч гарах холбоо, зүй тогтол, төрийн эрх байгууллагаас заавал мөрдөхөөр гаргасан дүрмийг хэлдэг хууль хэмээн тайлбарлаж байна. Хууль дүрэм, хууль ёс, хууль тогтоомж, хууль цааз гэх мэтээр холбоо үг үүсгэж бидний амьдралд өдөр тутам хэрэглэгдэж буй билээ.

čayaja (tʃa:dʒ): *čerig-ün čayaja gesen čing yang ildün-ü ir-dü adali qurča* Тус өгүүлдэрт илэрч буй *čayaja* хэмээх үг нь төрийн ёс, дүрмийг хэлдэг *cháozhì* 朝制 хэмээх хятад үг нь монгол хэлний мөрдөн хэвшүүлэхээр тогтоосон дүрэм журам, хууль, оноосон ял зэргийг илэрхийлдэг *čayaja* хэмээх үгийн гарал нь байж болно. Зарим судлаачид цааз хэмээх үгийг шажин хэмээх үгтэй гарал нэгтэй хэмээн үздэг билээ. Халх журмын A1b талд *yur-ban qosiyun-u yeke čayaja* (гурван хошууны их цааз) (Баярсайхан нар, 2009:971) гарч байна. Ямартай ч хожуу үеийн дурсгалаас илрэн гарч тус үг нь монгол хэлэнд харь үгийг зээлдэн авахдаа орчуулсан хоршоо үг болгон авдаг уламжлалыг баримтлан *хууль цааз* орж ирсэн бололтой. Энэ мэт олон үг хоршин монгол хэлэнд орж ирсэн байдаг бөгөөд түүний нэг жишээ нь манж хэлний хачин хэмээх үг монгол хэлний сонин хэмээх үгтэй хорчин *сонин хачин* гэх хоршоо үгийг бүтээсэн билээ.

yangju (jaŋdʒ): *arban čeng ši nar-uud, yeke jaŋgjun-du nigemösün iyimü yangju-tai öšiy-e boduju, ögügüilkü-ber januju bayiqu tulada-bar iyen biden yaŋaqin ilder talbiqu bui?* Хятад хэлний хэв, маяг, үлгэр, дүрс байдал, шинж, зүйл зэргийг илтэгдэг *yangzi* 样子 хэмээх үг нь монгол хэлний үгийн санд хэлбэр маяг, овор дүр, үзэмж, байдал, хүний зан төрх, төлөв байдал, сонин хачин, төрөл, зүйл гэх олон утгыг илтгэн *yangju* хэмээн оржээ. Мөн нэлээд олон тооны хоршоо үгийг үүсгэсэн байна. Жишээ нь янз байдал, янз маяг, янз донж, янзтай гоё, янзын муухай. Мөн янзыг нь олох буюу хэв маягийг нь тохируулах хэмээх хэлц үгийг хүртэл үүсгэсэн байна.

⁵⁶ Д.Төмөртогоо. 2018. Монгол хэлний үгийн гарлын тайлбар толь. 316. Улаанбаатар.

⁵⁷ Добу. 1983. *Үйсүржин монгол үсгийн дурсгалт бичгүүд*. Үндэсний хэвлэлийн хороо. 501-571. Бээжин.

Гурав. Хятад гаралтай манж зээллэг үг

Үгийн гарал судлал шинжлэх ухааны чанартай байдгийн нэгэн адил манж хэлнээс монгол хэлэнд орсон үгийг судлах нь бичгийн дурсгал, амьд хэлний олон нутгийн аялгуу, төрөл хэлтэй холбогдох үзэгдэл, өөрийн хэлний авиа зүй, хэл зүйн хөгжлийн хуулийн үүднээс тухай тухайн баримтыг цуваа цагийн үүднээс харшуулан түүхэн хэлшинжлэлийн аргаар судлах, түүнчлэн ормол үгс монгол хэлэнд хэрхэн нэвтэрч, хэрэглээ нь бэхэжсэн, утга болон хэлбэрийн хувьд яаж хувирсан, цаг үеийн нийгэм, соёлын харилцааны ямар онцлог нөхцөл байдалтай уялдсан зэргийг тодруулах олон талт шинжилгээг шаарддаг байна. Монгол хэлний нутгийн аялгуунуудад манж үг хэр орсон нь харилцан адилгүй ажээ. Бүрэнбаяр хуурчийн хуурдан хэлсэн “Гурван улсын үлгэр” дэх цөөн хэдэн хятад үгс манж хэлнээс монгол хэлэнд орсныг харж болно.

yamu (ja:mu: /ᠶᠠᠮᠤ/) “*marγaši-yin örlügegür yamu se-yin qural deger-e düng taikeü-i čao-yin yaġar ġalaju-la bayiyad kereg učir-i bolbal siidbürilekü-ber toytaġei*”, “*yamulaqu-bar iregsen sayid-uud*” дээрх жишээн дээр гарч буй *yámén* 衙门 хэмээх хятад хэлний эрт цагийн түшмэлүүдийн суух албан газрыг нэрлэж буй үг нь монгол, манж хэлэнд аль алинд нь орсон зээлдэн орсон байна. Монгол хэлэнд *yamun* хэмээн тэмдэглэж тус үг нь Манжийн үед алба шийдгэх газрыг нэрлэж байгаад эдүгээ тодорхой салбарын төрийн бодлого хэрэгжүүлэх төв байгууллагыг нэрлэх болжээ. Түүхэн баримтаас харахад Чан-йин-жүй дурсгалд зориулсан 1335 оны хөшөөний бичгийн 27 дугаар мөрт *yamun bayiyuluġad nouad-i tüšiküi-dür*⁵⁸ (яам байгуулаад ноёдыг түшихүүд) хэмээн гарч байна.


Бидний сурвалжид *yami*, *yamun*, *yamulaġsan*, *yamulaqu*, *yamulaġad*, *yamulaġei* хэмээх хэлбэрээр гарч буй тухайн үгийг “Монгол үгсийн язгуурын толь”-д “*yami(n)* хятадаар 衙门, 部, 职务 1· <хуучирсан> ноёд түшмэдийн албан хэрэг шийтгэх газар 2, зургаан хэлтэс 3, <хуучирсан> юань улсын үе дэх шашны байгууллагын тушаалтны нэр 4, <хуучирсан> зэрэг тушаал” хэмээгээд зөрчинд бас *yamun* гэнэ (Сэцэнцогт, 1980:2471). Түүхэн баримтаас харахад: Юань улсын судрын 34 дүгээр дэвтэрт, *Жао Мэний илбэн тохинуулах хэлтэс лүгээ харилцан ороод садан болсон тулд Сюань Жэн Юань яаманд тушааж харьяат цэрэг иргэнийг авч чангалан сахиж бэлтгэгтүн хэмээвэй*. Мөн 35 дугаар дэвтэрт *жич мужийн яамны түшмэд хамт Юньнанийг дайлахуйд цэрэг арав илүү түм хэмээн гарч байна*. Жүн-вэйн гэрэлт хөшөөний бичээст 1. *фун жи тай фу 237 Яргай 238 даргач Гамжу хаяа 239 яамнуудын гэрийн дэвсгэр аяг [a...]* 2. *хулгана жил Жи-жин найман он намрын тэргүүн сарын арван долоон[oo...]* хэмээн гарч байна. Тайлбарлавал: 1348 онд Яргай хотын даргач Гамжу Хаяа тэргүүтэн түшмэд энэ хөшөөг байгуулжээ. Хөшөө Нинся-гийн Жун Вэй хэмээх сянь-ий нутгаас олдсон бөгөөд хагарсны улмаас бүрэн бүтэн уламжлаагүй байна. Хөшөөнд хятад бичээстэйгээс гадна, хоёр мөр монгол бичээсийг нэмж сийлсэн ажээ (Жанчив, 2005:33). Чан-йин-жүй дурсгалд зориулсан 1335 оны хөшөөний бичгийн 27 дугаар мөрт *yamun bayiyuluġad nouad-i tüšiküi-dür*⁵⁹ (яам байгуулаад ноёдыг түшихүүд) хэмээн гарч байна. Манж хэлний үгийн санд хятад гаралтай зээллэг үг олон илэрдгийг нэг жишээ энэ болно. Мөн монгол, манж хэлэнд аль алинд нь зээлэгдэн орсон хятад гаралтай үгийг аль хэлнээсээ аль хэлэнд орсныг тодлох нь чухал билээ. Ямартай ч хятад гаралтай яам хэмээх үг нь монгол хэлний үгийн санд нэлээд эрт нэвтрэн өөрийн гэсэн орон байраа эзэлсэн байна.

dangsa (daŋs /ᠳᠠᠩᠰᠠ/): *yinggikü lai bol ečineken čerig-ün ġang dangsa-yi ilġarayulġu bayiyad ken-dü buday-a tayarday-i* хэмээх жишээн дээр гарч буй данс хэмээх үгийг профессор М.Баярсайхан манж хэлний *Dansa* хэмээх үг хятад хэлэнд 单子 *dān zī* хэмээн орсон гэж үзсэн болно (2017:232). Доктор С.Мөнхсайхан

⁵⁸ F.W.Cleaves. 1950. *The Sino-Mongolian Inscription of 1335 in Memory of Chang Ying-ġüi*. HJAS 13. 79-93.

⁵⁹ F.W.Cleaves. 1950. *The Sino-Mongolian Inscription of 1335 in Memory of Chang Ying-ġüi*. HJAS 13. 79-93.

хятад хэлний *dānzi* 单子 буюу бүтээлэг, хуудас хэмээх үгээс монгол хэлэнд тоо бүртгэл, баримтыг жагсаан бичсэн тэмдэглэл гэсэн утгаар орсон (2014:169) хэмээн дурдсан билээ. Jerry Norman “Манж англи хэлний дэлгэрэнгүй тайлбар толь”-д *records, register* (2013:54) бүртгэл, бүртгэх хэмээн орчуулсан байна. Ингээд монгол хэлэнд тоо бүртгэлд хөтлөх хуудсыг данс гэдэг болсон бөгөөд данс тооцоо, данс хараа гэх хоршоо үг үүссэн байна. Тус үгийн гарлыг нягтлах барим хараахан дутуу байна. Гэвч дээрх толь бичгүүдийг харахад тус үгийг монгол хэлний үгийн санд хятад хэлнээс бус манж хэлнээс зээлдэн орсон байх хэмээн үзэж доорх жишээг оруулав.



wadang (wa:dʏŋ / 𐰺𐰍𐰏𐰤): *tuy-un wadang tngri-yin jibar-tu miralʃayad* тус үгийг “Монгол үгсийн язгуурын толь”-д хятадаар包袱 боох баглах дөрвөлжин бөс хэмээн тайлбарлаад *wadangnaqu, wadanglaqu* үүссэн гэжээ. Мөн зөрчинөөр wadaŋ гэж дуудна (Сэцэнцогт, 1980:2471). Харин доктор С.Мөнхсайхан хятад хэлний боох юм гэсэн утгатай 包单 гэх үг монгол хэлэнд орсон хэмээн үзсэн байна (2014:158). Харин “Монгол хэлний үгийн гарлын толь”-д хятад хэлний bāo dān боодол гэх үг гэж үзсэн байна (Төмөртоогоо, 2018:68). Jerry Norman “Манж-англи хэлний дэлгэрэнгүй тайлбар толь”-д *a cloth wrapping* (2013:303) бүртгэл, бүртгэх хэмээн орчуулсан байна. Манж монгол хятад тольд “wadan 布单子” (Билиг нар, 2013:1010) хэмээн тэмдэглэсэн байна. Орчин цагийн монгол хэлэнд ваадан (баадан) 1. Юм боож орооход зориулсан дөрвөлжин бөс даавуу: **вааданд боох** (дөрвөлжин бөс даавуунд боох), **дээлийн ваадан** (дээл боох бөс даавуу), **мод ваадан морь эмээлтэй** (а. Бүх зүйл бэлэн болсон нь; б. Хөзөр, даалуу тоглоход хожлын бүх мод ирсэн нь), 2. Майхны үүдэн талын зөрүүлэг хормой: **вааданг нь сөхөх** (майхны үүдийг нь сөхөх), **вааданг нь хаах** (майхны үүдийг нь хаах) 3, Шүхрийн задарч тэлэгдэх орой 4, Хөлөг онгоцны дарвуулын бөс хэлдэг байна. Тухайн үгийг сурвалж бичгүүдээс сурвалжлаад олоогүй бөгөөд манж хэлнээс монгол хэлний үгийн санд орсон бололтой.

Дөрөв. Дүгнэлт

Эртнээс хөрш залгаа байсан үндэстэн ямар нэгэн харилцаагүй байна гэж байхгүй. Монголчууд эртнээс хятад, зөрчидтэй дайн байлдаан соёлын харилцаатай байсан ард түмэн. Ялангуяа Юань гүрний үед нэгэн тугийн дор амьдарч байсан. Дараа нь Юань улсаас хойш Мин улсын үед зүүн монголчууд манж хоёр их харилцаатай байсан билээ.

Бүрэнбаяр хуурчийн хуурдан хэлсэн “Гурван улсын үлгэр” дэх хятад зээллэг үгсийг судлахдаа үгийн сан утга орноор нь зүйлчлэн ангилж, ямар цаг үед, хоёр гүрний ямар төрлийн харилцаанаас үүдэж тухайн үг хэллэг орсон болохыг тодорхойлох явдал чухал байна. Учир нь үгийн сан утга зүйн орон (Lexico-Semantical field) гэдэг бол аливаа хэлний үгийн бүх сан хөмрөг, эсвэл тухайлж сонгосон үгийн их бүрдлийг нийгэм хэлний харилцааны орчин нөхцөлтэй нь уялдуулан утга зүйн үүднээс зүйлчлэн тус бүр багц болгон ангилж шинжилдэг арга юм. Монгол толь зүйн уламжлалд “Таван зүйлийн үсгээр хавсарсан манж үгийн толь бичиг” гэх мэт нь тэнгэрийн зүйл, газрын зүйл, ёслолын зүйл гэх мэтээр үгсийг ангилдаг нь энэ үгийн сан утга зүйн орноор ангилдаг баримжааг их эртнээс хэрэглэж байсан бас баримт гэж үзэж болно. Энэ нь чухамдаа хэлний тэмдгийг нийгэм хэл шинжлэлийн (Social linguistics) үүднээс тайлбарлах нь зүйтэй байна гэсэн санааг хэлэх гэсэн юм. Энэ мэтээр бид ангилан оноосон нэрийг зээллэг үгэнд оруулаагүй бүртгэн гаргасан болно.

Нэгэнт хуурын үлгэр нь олон үеийн, олон газар оршин сууж байсан олон үлгэр, тухайн үлгэрийг хуурдан хайлсан гэдэг бол тэр үлгэрийг өөрчлөх нь бүтээлч үйл ажиллагаа уг үлгэрт заавал тусах учиртай. Иймд үлгэрийн ерөнхий өгүүлэмж, агуулга нь хэвээр эсвэл нэг янзын байна гэж үзэх боломжтойг ч үзэж хувь бодгаль буюу тухайн хуурчийн уг бүтээлийг агуулга, зохиомж түүний уран яруу өгүүлэх өөрийн гэсэн өнгө аясаар заавал амилуулж, шинээр бүтээсэн байна гэсэн үг. Үүнийг энэ Бүрэнбаяр хуурчийн хуурдан хэлсэн “Гурван улсын үлгэр” -ээс ажиглахад бас мэдэгдэж байна. Энэ бол сэтгэл зүй (Psychologist-Psycholinguistics) сэтгэц хэл шинжлэлийн туршилтад нотлогдсон зүйл гэж үздэг.

Монгол хэлээрх түүхэн болон бусад сурвалж бичиг, албан бичиг захидал, толь бичгүүдэд дээрх үгс яг хэдий үеэс тэмдэглэгдэж эхэлснийг боломжийн хирээр байцаан сурвалжилсан бөгөөд зарим хятад гаралтай манж үгс нь XVII зууны үеэс, ихэнх нь XVIII зуунаас эхлэн монгол хэлээрх бичиг зохиолд тохиолдож байгаа нотлов.

Энэ нь Чин улсын үед хорчин монголчуудын язгууртан нар чин улсын төртэй хамгийн зузаан харилцаатай байсан үе гэхэд болно. Тэр үед хорчин монголчуудаас Нурхаачийн гэр бүлтэл хамгийн анх ураг төрлийн харилцаанд орсон билээ. Боомт орохоос өмнөх тэмдэглэлийг үзвэл: Чингийн төр ба хорчин аймаг 33 удаа ураг барилдаж, боомт орсноос Чин улсын сүүлч хүртэл 130 удаа ураг барилдсан байна. Үүнд: Хорчин гүнжийн манжид бэр болж очсон нь манж гүнжийн тоотой харьцуулахад монгол 94: манж 36 хүрч бараг гурав дахин их байна (杜家冀 (Ду Жиажи), 2003:15). Энэ нь наад зах нь манж хэлний төрлийн харилцааны нэрийдэл, цаашлаад тэдний соёлын хэрэглээг манж хэлээр дамжуулан хорчин аман аялгуунд зээлдэн авсан байх нийгэм түүхийн байдалд суурилагдсан байх бололцоо их байна. Чин улсын язгууртан, ван ноёдтой ураг барилдсан хорчины гүнж нар олон тооны үгийг дайж очсон байх боломжтой билээ. Тухайн өгүүлэлд дурдаагүй ч манж хэлний нэлээн олон жишээ тохиолдож буй билээ. Түүний нэг нь омбол хэмээх үг хорчин аман аялгуунд зээлсэн шиг байна. Тийм үгийг зээллэг үгээр авч үзэх нь зүйтэй гэж үзэв.

Бүрэнбаяр хуурчийн хуурдан хэлсэн “Гурван улсын үлгэр” т гарч буй монгол хэлэнд орсон хятад зээллэг үгийг гарлын үүднээс зайлшгүй нягтлан шинжилж, зохих тайлбар хийх ёстой гэж үзэж тайлбарлав. Учир нь зээллэг үг болгон тухайн үндэстэн, угсаатан бүрийн уламжлалт соёл, ёс заншил, ахуй байдлын онцлогтой уялдуулж, нийгмийн гишүүн бүрийн харилцааг тохируулж, нийгэмшүүлэх, бүр энгийнээр хэлбэл өөриймсүүлж байгаа зүтгэлт үзэгдэл гэж үзэж байна.

Тиймээс зарим үгсийн гарлыг тодруулснаар үлгэрийн утга санааг улам нарийн, тодорхой ойлгоход тус нэмэр болно хэмээн үзэж байна.

Номзүй

Баярсайхан Б., Оюунбилэг Б., Батбаяр Б. 2009. “Халх журам” эх бичгийн судалгаа. 2009. Улаанбаатар.

Баярсайхан М., Энхсүвд Б. 2017. Монгол хэлэнд орсон манж үгсийн тухай. Proceedings of The 13th Seoul International Altaistic Conference, Contemporary outlooks on Altaic languages. Mongolia.

Билиг, Улаантуяа. 2013. Манж монгол хятад толь. ҮХХ. Бээжин.

Дамдинсүрэн Ц. 1979. Монгол уран зохилын дээж зуун билиг оршвой. ӨМАХХ.

Добу. 1983. Уйгуржин монгол үгсийн дурсгалт бичгүүд. ҮХХ. Бээжин.

Жанчив Ё. 2005. Сонгодог монгол бичгийн өмнөх үеийн дурсгалууд. Corpus scriptorum, Tomus II. Улаанбаатар.

Мөнхсайхан С. 2014. Монгол хэлний хятад гаралтай үгийн судлал. Улаанбаатар.

Поппе Н. 1938. Монгольский словарь Мукаддимат ал-Адаб. Труды института

- Востоковедения XIV. часть I-II. М-Л. 60-87, 93-451.
- Сэцэнцогт.** 1980. *Монгол үгсийн язгуурын толь*. ӨМАХХ. Хөххот.
- Төмөртогтоо Д.** 2018. *Монгол хэлний үгийн гарлын тайлбар толь*. Улаанбаатар.
- Cleaves F.W.** 1950. *The Sino-Mongolian Inscription of 1335 in Memory of Chang Ying-jiü*. HJAS 13. 79-93.
- Cleaves F.W.** 1951. *The Sino-Mongolian Inscription of 1338 in Memory of Jigünte*. HJAS 14. 1-104.
- Haenish E.** 1953 (1954). *Mongolica der Berliner Turfan Sammlung. I. Ein buddhistisches Druckfragment vom Jahre 1312*. ADAW Nr. 3. 1953. Berlin. 1954. S. 22+24 Tafeln.
- Jerry Norman.** 2013. *Comprehensive Manchu-English Dictionary*. Harvard-Yenching Institute Monograph Series.
- Kuribayashi H.** 2003. *Word- and Suffix-Index to Hua-yi Yi-yu based on the Romanized Transcription of Ligeti*. Sendai. 63-166.
- Serruys H.** 1977. *The Office of Tayisi in Mongolia in the Fifteenth Century*. HJAS 37. 353-380.
- Tumurtoogoo D.** 2006. *Mongolian Monuments in Uighur-Mongolian Script (XIII-XVI Centuries)*. Taipei.
- 杜家冀. 2003年. 《清朝满蒙联姻研究》. 人民出版社.

Товчилсон нэр

- HJAS-** Harvard Journal of Asiatic Studies
JAS- Journal of Asian Studies
БХҮИС - Баруун Хойдын Үндэстний Их Сургууль
ГУНШУ- Гүн ухаан, нийгмийн шинжлэх ухаан
МСӨТ- Монгол судлалын өгүүллийн түүвэр
МСХ- Монгол судлалын хүрээлэн
МТХБ- Монгол түүх хэл бичиг
МУИС- Монгол Улсын Их Сургууль
МХЗТ- Монгол хэл зохиол түүх
МХСС- Монгол хэл соёлын сургууль
МХУЗ- Монгол хэл утга зохиол
ӨМАХХ- Өвөр монголын ардын хэвлэлийн хороо
ӨМБИС- Өвөр монголын багшийн их сургууль
ӨМИС- Өвөр монголын их сургууль
ӨМИСХХ- Өвөр монголын их сургуулийн хэвлэлийн хороо
ӨМӨС- Өвөр монголын өдрийн сонин
ӨМСХХ- Өвөр монголын соёлын хэвлэлийн хороо
ӨМСХХ- Өвөр монголын соёлын хэвлэлийн хороо
ӨМҮБДС- Өвөр монголын үндэстний багшийн дээд сургууль
ӨМХХ- Өвөр монголын хэвлэлийн хороо
ТҮИС- Төвийн Үндэстний Их Сургууль
ҮХХ- Үндэсний хэвлэлийн хороо
ЭШС- эрдэм шинжилгээний сэтгүүл

Abstract

Oral tales, which known as “tales of the fiddle” (quγur-un üliger or bengsün-ü üliger) derived in eastern part of Inner Mongolia, is well-inherited to this day and has been the focus of many Mongolist scholars since long ago. We chose the “Romance of the Three Kingdoms (in Mongolian: γurban ulus-un üliger; in Chinese: 三国演义)” which was performed by Bürenbayar bard (quγurči, Lit: the fiddle player) as a main object of our research work. In August 1984, Bürenbayar, an important source of the Khorchin dialect, performed the tale of the fiddle “Romance of the Three Kingdoms” for a total of 62 hours on the Khulunbuir Radio - 8 - Committee. When we studied this tale of the fiddle from perspectives of the lexicological study, we revealed that the study of local/regional dialects and loan words was still lacking in the research field of tales of the fiddle. it is considered that is need to analyze and to give an adequate explanation for the borrowed words from Chinese language to the Mongolian language inside “Romance of the Three Kingdoms” which was performed by the bard Bürenbayar. The 20 borrowed words, which commonly occurs in other Mongolian dialects, are analyzed and explained based on Mongolian primary sources. All of the Manchu words within “Romance of the Three Kingdoms” which was performed by the bard Bürenbayar, were marked up and were eventually listed 20 Manchu words. For listing it, the origin of that words and literature review were - 10 - introduced by word for word. As a result, these words were considered that several words which entered to Mongolian language according to cultural exchange between the Khorchin Mongolians and Manchu, and concluded that some words which entered to Mongolian language in ancient time. Each borrowed word is considered to be an effort to adapt and socialize the relations of each member of the society in accordance with the traditional culture, customs and way of life of each nation and ethnic group. First appendix part included all 685 words which were explained one by one in this research work. Especially, every word was transcribed by Mongolian script and international phonetic transcription, and every borrowed word was explained by words of source language, and was arranged according to the structure of our research work.